Итгэл, сэтгэл, хандлага нь үл үзэгдэх мөртлөө үл тасрах сэтгэлийн учигаар хүмүүсийг гагнан холбосон сэтгэхүйн үр дүн юм. Орчин үед морь унаж сэлэм эргүүлж явдаг цэргийн дарга шиг бус. хүний сэтгэлийг эзэмдэж, баг хамт олны хүссэн зүг, зорьсон зорилгодоо хөтөлж хүргэж чадахуйц шинэ үеийн манлайлагч, лидер байх нь чухал юм.

Удирдагчийн ур чадвар, итгэл, хандлага нь харилцан хамаарал, шүтэлцээтэй удирдагчийн удирдах арга барилын гурвалжин юм.

***Ч.Батжаргал*** *- Хууль сахиулахын удирдлагын*
*академийн 821 дүгээр дамжааны суралцагч, дэд хурандаа*

## ХИЛИЙН ОТРЯДУУДЫН АЛБАНЫ БЭЛЭН БАЙДЛЫН УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТАД ТУЛГАМДАЖ БУЙ АСУУДАЛ, ШИЙДВЭРЛЭХ АРГА ЗАМ

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, улсын хилийн халдашгүй дархан байдлыг хангахад нөлөөлөх чухал хүчин зүйл болох бие бүрэлдэхүүний албаны бэлэн байдал, бэлтгэлжилт, түүнийг дээшлүүлэхэд чиглэсэн санал, дүгнэлтийг дэвшүүлэхийг зорилоо.*

***Түлхүүр*** *үг: Албаны бэлэн байдал, онцгой нөхцөл байдал, хил хамгаалалт, зэвсэглэл инженер техник, сургалт бэлтгэл, дохиолол хяналтын хэрэгсэл.*

Хилийн отрядуудын 2015-2016 онд хариуцсан хэсгийн цагийн байдал, гадаад болон дотоодоос гарсан хилийн зөрчилд дүн шинжилгээ хийхэд сүүлийн үед хөрш орны иргэд, манай иргэдээс хамтран хилийн зөрчил гаргах, хил дамнасан хууль бус ажиллагаа зохион байгуулалтад шилжиж, зэвсэг, галт хэрэгсэл, хар тамхи, мансууруулах бодис, түүхийн үнэт зүйлс. алт, эрдэс баялгийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэх, хулгайн ан хийх, гадаадын зарим иргэд газар нутаг худалдан авч эзэмших, эзэмшихийг санаархах зэрэг зөрчил гаргаж байгаа нь харагдаж байна.

Иймд үүсэж байгаа цагийн байдал, хилийн отрядын цаг агаар, газар орны онцлогтой уялдуулан хил хамгаалалт, албаны бэлэн байдлыг боловсронгуй болгох шаардлага бий болж байна.

Хил хамгаалалтын бүх шатны удирдлага нь удирдахуйн ухааны шинжлэх ухааныг судалж, шинжлэх ухааны онолын үндэстэй практик үйл ажиллагаатай уялдуулан удирдах нь амжилтад хүрнэ гэж дүгнэж байна.

Хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны бэлэн байдлын журамд албаны бэлэн байдлын зэргийг байнгын, өндөржүүлсэн, бүрэн[1] гэсэн 3 зэрэгт шилжүүлж ажиллахаар заасан.

Олон хувилбараас хамгийн зөв оновчтойг олж тогтоох бөгөөд уян хатан, олон талаас нь авч үзэх, зөвхөн нэг талыг барин туйлшрахгүй байх нь оновчтой, зөв шийдвэр гаргах чухал нөхцөл болдог[1 2].

Алба-байлдааны бэлэн байдлыг хангах удирдлагын үйл ажиллагааны бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

> Онцгой нөхцөл байдал үүсэх, хилийн эрлийн үед отряд. заставуудын бүх нөөц, боломжийг чадварлаг удирдахад чиглүүлэн сурган дадлагажуулах;

> Хилийн зөрчлийг таслан зогсоох, саатуулах хил зөрчигчийн учруулж болзошгүй аюул, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, иргэн, байгууллага, тэдгээрийн эд хөрөнгийг хамгаалах арга хэлбэр, тактик. үйл ажиллагааны дараалал, ашиглах хүч хэрэгслийн тооцоог нарийвчлан гаргах, эзэмших зэрэг болно[3].

Бэлэн байдлыг хангах гол асуудал нь бие бүрэлдэхүүний бэлтгэлжилтийн түвшин бөгөөд бэлтгэлжилтийг дээшлүүлэхэд дараах арга хэмжээг авна. Үүнд:

> Хилийн отрядын албаны бэлэн байдлыг дээшлүүлэх зорилгоор төрөл мэргэжлийн алба, тасгийн дарга нартай явуулах сургалт, бэлтгэлийг төрөлжүүлэн дэс дараалалтай зохион байгуулах, бусад орны хил хамгаалах байгууллагын цэргийн хээрийн сургууль, дадлага, туршлагыг дэлгэрүүлэх, судлах ажил зохион байгуулах;

> Хилийн отрядын шуурхай ажиллагааны болон тусгай томилгоот бүлгийн бүрэлдэхүүнийг орчин үеийн зэвсэг, хамгаалалтын тоног, тусгай хэрэгсэл, төрөл бүрийн байлдааны зориулалттай техник, технологиор хангах, ашиглах дадлага, чадварыг эзэмшүүлэх;

Зэвсэглэл, инженер техникийн бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авна. Үүнд:

> Орчин үеийн дохиолол-хяналтын системээс хэт ягаан туяаны дохиолол зэргийг хил хамгаалалтад ашиглах, үүний зэрэгцээ GPS, дуран

[1] Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2011 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Хил хамгаалах алба, үйл ажиллагааны бэлэн байдлын тухай мн/06 тоот тушаал.

[2] *Ц.Цэрэндорж.* Бидний менежмент. - УБ., 2010. 10 дахь тал.

[3] Хил хамгаалах ерөнхий газрын даргын 2011 оны 11 дүгээр сарын 13-ны өдрийн Хил хамгаалах алба, үйл ажиллагааны бэлэн байдлын тухай мн/06 тоот тушаал.

харааны хэрэгсэл зэрэг техник хэрэгслийг хил хамгаалалтад өргөнөөр нэвтрүүлж. хилийн отряд, заставт хяналтын төв байгуулах;

> Камер, дохиололын хэрэгсэл. нисгэгчгүй нисэх хэрэгсэл ашиглах анхан шатны сургалтад хилчдийг хамруулах;

Албаны бэлэн байдлыг хангахад харилцан ажиллагааг дээшлүүлэх чиглэлээр дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

> Харилцан ажиллагаатай зэвсэгт хүчин, цагдаа, тагнуул болон орон нутгийн байгууллагуудтай ажиллах журмыг нарийвчлан тодотгож, албажуулан тогтоосон хугацаанд хамтарсан сургууль, дадлагыг тогтмол хийж үр дүнг тооцох;

> Хилийн зөрчил, болзошгүй ажиллагааны үед харилцан ажиллагааг зохион байгуулахдаа сүүлийн үеийн техник, тоног төхөөрөмжийг ашиглах;

Хил хамгаалах байгууллагаас хил хамгаалалт, албаны бэлэн байдлыг сайжруулах орчин үеийн дэвшилтэт техник хэрэгслийг хил хамгаалалтад нэвтрүүлснээр хилийн отрядын албаны бэлэн байдлыг боловсронгуй болгох арга зам тавигдана гэж үзэж байна. Үүнд:

> Хөдөлгөөнт харуул, хилийн манааг дулаан мэдрэх зарчимд үндэслэгдсэн зөөврийн хяналтын хэрэгслээр хангах;

> Судалгаа, шинжилгээний багийг бүрдүүлэн нисгэгчгүй нисэх хэрэгсэл үйлдвэрлэдэг өөрийн орны болон гадаад орны компаниудтай гэрээ байгуулан хамтран ажиллаж, бүс нутгийн онцлогт тохирсон отряд бүр нэг иж бүрдэл нисгэгчгүй нисэх хэрэгслээр хангах.

Судлаач миний зүгээс хилийн отрядын албаны бэлэн байдлыг боловсронгуй болгох чиглэлээр дараах санааг дэвшүүлж байна. Үүнд:

1. Хилийн отряд, заставуудын бүлэг, хүн нэг бүрийн хоногийн хүнсийг орчин үеийн шийдэлтэй, монгол хүний бие физилогид тохирсон, 2-3 жил хадгалах боломжтой, иж бүрдэл бүхий хүнстэй болгох арга хэмжээг, хүнсний хувийн хэвшлийн байгууллага, хүнсний технологи болон мэргэжлийн хяналтын байгууллагуудтай хамтарсан судалгааны баг томилон ажиллуулж шийдвэрлэх шаардлагатай байна.

2. Монгол Улсын Батлан хамгаалах бодлогын үндэс баримт бичигт тайван цагт хуулиар хүлээсэн чиг үүргээ биелүүлж, дайны үед зэвсэгт хүчний бүтцэд үүрэг гүйцэтгэнэ гэж зааснаар хилчин офицер бүр Зэвсэгт хүчний ерөнхий цэргийн тактик, давшилт, хориглолт, тактикийн таних тэмдэг, ҮОХЗ-ийн бэлтгэл зэргийг мэддэг, хийж дадлагажсан байхыг шаардаж байна. Иймд ХХБ сургалтын хөтөлбөр төлөвлөгөө, мөн ХСИС-

ийн ХСУА, Хилийн сургууль, Онцгой байдлын сургуулиуд хичээлийн хөтөлбөртөө“Ерөнхий цэргийн тактик” хичээлийг оруулах шаардлагатай.

Түүнчлэн улсын хил хамгаалалтын найдвартай байдлыг хангах зорилго бүхий хилийн инженерийн байгууламжийг сэргээн засварлах, шинээр бий болгох, хариуцсан хэсгийн газар зүйн онцлогт тохирсон шинэ техник. технологийг хил хамгаалалтад нэвтрүүлэх,ашиглагдаж байгаа техник технологи нь өнөөгийн хил хамгаалалтын бэлэн байдлыг бүрэн дүүрэн хангаж чадахгүй зэрэг учир дутагдалтай байгааг харгалзан үзэж шинэчлэлт хийх, хилийн манааны уналгыг газар оронд тохирсон туулах чадвар сайтай, эдийн засагт хэмнэлттэй техник хэрэгсэл нэвтрүүлэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хилийн отряд, заставын удирдлагын бүтэц, зохион байгуулалт, зэвсэглэл техник, сургалт бэлтгэл, албаны болон материаллаг техникийн хангалтын нөөц, бие бүрэлдэхүүний ёс суртахуун-сэтгэл зүйн бэлтгэл. албаны сахилга зохион байгуулалтыг бэхжүүлэх асуудал нь албаны бэлэн байдлыг дээшлүүлэх, үүссэн байдлын үед зохицон ажиллах чадвартай байхад чиглэгдэнэ гэж үзэж байна.

***Г.Даваатогтох*** *- Хууль сахиулахын удирдлагын академийн 821 дүгээр дамжааны суралцагч, дэд хурандаа*

## ХИЛ ХАМГААЛАХ БАЙГУУЛЛАГЫН ҮНДСЭН ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД “МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС хилийн ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГО”-ЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ХАНГАХ ЗАРИМ АСУУДАЛ

***Хураангуй:*** *Энэхүү илтгэлээр хил хамгаалах байгууллагын үндсэн үүргийг хэрэгжүүлэх, улсын хил хамгаалалтын талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх зарим асуудлыг авч үзлээ.*

***Түлхүүр*** *үг: Хил хамгаалалт, хил хамгаалах байгууллага, төрөөс хилийн талаар баримтлах бодлого.*

Хилийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх нь хил хамгаалах байгууллага болон Монгол Улсын хувьд чухал асуудал юм.

Энэ чухал асуудлыг илүү боловсронгуй болгохын тулд “Монгол Улсын төрөөс хилийн талаар баримтлах бодлого"-ыг төрөөс баталж өгсөн.

Энэхүү бодлогын 5 дахь хэсэгт: ‘*Зорчигч, тээврийн хэрэгслийг улсын хилээр нэвтрүүлэх үйл ажиллагааг шуурхай болгож, хилийн боомт газарт ажиллах хяналтын албадын үйл ажиллагааг нь уялдуулан, нэгдсэн зохицуулалтад оруулах;" 31. дэх хэсэгт: «Хил хамгаалах албыг ямар ч нөхцөлд улсын хилийн халдашгүй дархан байдал, хил орчмын нутаг